



# Leapfrog Geo-ийн тусламжтайгаар геологийн өгөгдлийн зүй тогтлыг танин мэдье

Геологийн өгөгдлийн тайлал, нэгтгэл, дамжуулалтыг богино хугацаанд  
гүйцэтгэдэг салбартаа тэргүүлэгч 3D загварчлалын програм



# Геологийн тайлалдаа цагаа зориул

Leapfrog-ийг геологичид геологичдодоо зориулан бүтээсэн. Ажлын зөв дараалал, өгөгдөл боловсруулалтын хурд, дүрслэл зэрэг нь багууд хамтарч оновчтой шийдвэр гаргахад тусалдаг.

## Тайлал хийхдээ цагаа зориул

Хэрэглэхэд хялбар хэрэгслүүдийг ашиглан геологийн загвараа байгуулж, илүү сайжруулаарай. Их хэмжээний өгөгдлийн багцыг програмд оруулж, өгөгдлөөс шууд загвараа үүсгэдэг нь таны цагийг хэмнэх давуу талтай. Геологийн өгөгдлөө 3D орчинд дүрслэн харснаар тайлал хийх төсөөллийг тань сайжруулна.

Загварчлалдаа шинээр мэдээлэл нэмэх үед өмнө нь үүсгэсэн түүнд хамааралтай загварууд мөн адил шинэчлэгдэж байдаг. Leapfrog Geo-ийн хэрэглэгдэхүүн болох хайгуулын өгөгдлийн шинжилгээ, зайн функц, структурын загварчлал, судал болон хагарлын загварчлал, интерполяц функц зэргээр өгөгдөлд шинжилгээ хийхэд хурдан бөгөөд ойлгомжтой байх болно



## Тодорхойгүй байдал, эрсдлийг бууруул

Олон боломжуудыг зэрэг туршиж загвараа илүү хурдан сайжруулах боломжтой. Эдгээр загваруудаа хадгалж, өөр бусад хувилбаруудтай харьцуулж мөн нэгтгэх боломжийг олгодог.


Өөр хувилбаруудыг хуулбарлах, өөрчлөх, турших, дамжуулах үйл явц хурдан байдаг. Загварчлал үүсгэхэд оролцсон дата хувьсагчуудыг хянахын тулд байнга шалгах хэрэгтэй.

Тайлбар тэмдэглэгээ бүхий 3D загвар, 2D зүсэлтүүдийг танилцуулж техникийн баг болон бусад оролцогч талуудыг нэгдсэн ойлголтод хүргэх ба санаагаа илүү тодорхой харуулахын тулд төслийн дүрс бичлэг, нягтрал сайтай зургийг гарган авч тайлан танилцуулгадаа хавсаргах боломжтой.

## Бүх өгөгдлүүдийг нэгтгэ

AcQuire, Maptek, ioGAS Link, IMDEXHUB-IQ, ALS Coreviewer, Coreshed, Imago зэрэг салбартаа тэргүүлэгч програмуудын өгөгдлийг шууд холбох боломжтой

GIS, зураглал, цооног, дээжлэлт, геофизик, структур, торлол, зүсэлт болон геохими зэрэг олон төрлийн өгөгдлийг импорт, экспорт хийх ба тэдгээртэй ажиллах боломжийг бүрдүүлсэн.



# Хамгийн сайн загварчлалыг хамгийн хурдан хугацаанд

Геологичдод зориулсан хялбарчилсан ажлын зарчим болон хэрэглэгдэхүүнүүдийн тусламжтайгаар өөрийн санаагаа туршихад болон оновчтой шийдвэр гаргахдаа цагаа зарцуулаарай.

## Leapfrog геологийн загварчлалд:



### Хялбар хэрэглээ

Leapfrog Geo нь геологичдын хувьд хэрэглэгдэхүүн нь болсноор зүй тогтол, дэс дараатай ажлын үйл явцыг бий болгож цаг хугацааг хэмнэх ач холбогдолтой. Хэрэглэгчид програмын үндсэн зарчмуудыг богино хугацаанд сурч, эзэмших боломжтой ба өөрийн цагийг загварчлал болон геологийн тайлал хийхдээ зориулах боломжийг олгоно.



### Домэйн загварчлал

Төсөл дэх өрөмдлөг, структур, дээжлэлт, зүсэлт, торлол зэргийн мэдээллүүдийг ашиглан богино хугацаанд геологийн цогц загварыг үүсгэнэ.

- Өгөгдлийг цэгцлэхэд стандарт тогтоох, хэрэглэгчийг тохируулж өгөх
- Гадаргуу, эзлэхүүн, судлыг давхрагазүйн дарааллаар загварчлах
- Нарийн төвөгтэй судлын системийг загварчлах
- Структурын мэдээллийг ашиглан гадаргууг загварчлах
- Хагарлын систем дэх хагарал, тэдгээрийн хоорондын хамаарлыг тодорхойлох.



### Тоон загварчлал

Цооногийн мэдээлэл болон цэгэн мэдээллийг ашиглан изо гадаргууг босгоно. Мөн тоон өгөгдлийг ашиглан анхдагч байдлаар дүрслэн харах боломжтой.

- Изо гадаргууг хурдан үүсгэж анхдагч загвараас тайлалтыг хийх
- Анизотропийг оруулах
- Цаашдын ажлыг чиглүүлэх шалгуур үзүүлэлтийн загварыг үүсгэх
- Олон домэйн интерполянтуудыг үүсгэх
- Изо гадаргуу, интерполянтын хэмжээ болон композит өгөгдлийг экспортлох
- Бүтцийн өгөгдлийг нэгтгэх замаар геологийн хувьд бодитой зэрэглэлийн домайнуудыг бий болгоно
- Нөөцийн тооцооллын өргөтгөл дээр Leapfrog Edge-г нэмж нөөцийн найдвартай тооцоолол хийх.



### Дүрслэл

3D хэлбэрээр хурдан дүрслэх чадвартай байх нь нарийн төвөгтэй өгөгдөлд хүртэл тодорхой, ойлгомжтой байдлыг бий болгодог.

Интерактив 2D болон 3D дүрслэх хэрэгслүүд нь таны өгөгдөлд дүн шинжилгээ хийж зүй тогтлыг олоход тусалдаг. Загварыг дурын өнцгөөс харж, чиг хандлагыг олж, алдааг илрүүлэх боломжтой.

- Scatter plots, Q-Q plots, box plots, histograms зэргийг ашиглан дүн шинжилгээ хийх
- Бүтэцлэгдсэн өгөгдлийг 2D эсвэл 3D хэлбэрээр дүрслэх
- Олон загваруудын холбоо хамаарлыг харуулсан scene үүсгэх
- Загварын дотор хэсгийг харахын тулд зүсэлт хийж харах, мөн гаднах хэсгийг бүдгэсгэж харах
- Цооногийн мэдээллийг сонгох, харах, цэгцлэх



### Блок загварчлал

Блок загваруудыг 3D хэлбэрээр хялбархан байгуулж, шинэчилдэг.

- Isatis болон UBC өргөтгөлөөр блокзагваруудыг импортлох
- Геологийн болон тоон загвараас блокуудад шинж чанарыг оноох
- Загваруудыг бусад салбарт хэрэглэгддэг өргөн хүрээний нийтлэг өргөтгөлөөр экспортлох

Нэмэлт Leapfrog Edge өргөтгөлтэй хослуулснаар нөөцийг тооцоолох бүрэн шийдлийг танд өгнө.



### Хүртээмжтэй байдал

Өөрийн үүсгэсэн мэдээлэл загварчлалыг 2D 3D зураг болон видеогоор бусад хүмүүст үзүүлж хуваалцах боломжтой. Ялгаатай түвшний техникийн мэдлэгтэй багийн гишүүд болон оролцогч талуудад таны загварыг ойлгон шийдвэр гаргахад нь тусална.

- Загварын шаардлагатай хэсгийг харуулсан 3D дүрсийг тохируулж хадгалах
- Хураангуй дүрсэнд нэмэлт мэдээлэл оруулах
- Render images-г тайланд ашиглах
- Leapfrog Viewer-д displayed/shared хийх боломжтой дүрсүүдийг файл болгон экспортлох боломжтой
- Видео үүсгэж экспортлоход дүрсүүдийг ашиглана
- Leapfrog дээрх төслүүдийг хянах, багууд хамтдаа нэг төсөл дээр ажиллах зорилгоор Seequent Central-д нийтэлнэ
- Leapfrog Viewer-ийг үнэ төлбөргүйгээр ашиглан загвараа хэнтэй ч хуваалцах боломжтой.




## Хялбар нэвтрэлтийн систем

Seequent ID нь танд интернэттэй орчинд хаанаас ч нэвтэрч, Leapfrog Geo програмын шинэчлэлүүдийг хүлээн авах боломжийг олгоно.

Интернэттэй үед нэг удаа нэвтэрснээр таны програм хангамж таны компьютер дээр 30 хүртэл хоног интернэт холболтгүйгээр ажиллах болно.

MySeequent хаягаараа нэвтэрч гүнзгийрүүлсэн сургалт, арга хэмжээнүүд, түүнчлэн хэрэгтэй зөвлөгөөг олж мэдэх боломжтой.



A better understanding of the earth  
creates a better world for all

[seequent.com](http://seequent.com)

Seequent, a Bentley Company



ТРИГТЕК ХХК

Монгол улс, Улаанбаатар хот,  
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпын  
гудамж, 18-р байр 13 тоот

+976 7737-6002  
[hello@trigteq.com](mailto:hello@trigteq.com)  
[www.trigteq.com](http://www.trigteq.com)